



**НИЙСЛЭЛИЙН  
СОНГИНОХАЙРХАН НЭГДСЭН ЭМНЭЛГИЙН  
ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2023 оны 01 сарын 28 өдөр

Дугаар 05

Улаанбаатар хот

┌────────── Тархины үхэл тодорхойлох баг ─────────┐  
байгуулах тухай

Монгол Улсын Донорын тухай хууль 10 дугаар зүйлийн 10.1.2, Эрүүл мэндийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.7, 20 дугаар зүйлийн 2.1 Эрүүл мэндийн сайдын 2019 оны А/164 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт, Эмнэлгийн дүрмийн 3 дугаар зүйлийн 3.2.1 Хөдөлмөрийн дотоод журмын 2 дугаар зүйлийн 2.6.3 дах заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь

1.Эмнэлгийн тархины үхэл тодорхойлох багийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, ажиллах журмыг хоёрдугаар, тархины үхэлтэй боломжит донорыг тандан судалж, үнэлэх, тархины үхлийг тодорхойлох эмнэл зүйн шалгуурыг гуравдугаар, тархины үхлийг шинжлэн бүртгэх картыг дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.

2.Мэргэжлийн эмч хамтарсан үзлэг, тархины үхлийн эмнэлзүйн шалгуур, сорилууд холбогдох шинжилгээнүүд, батлах тархины цахилгаан бичлэг, компьютер томографийн шинжилгээний дүгнэлтийг үнэлэн мэргэжлийн өндөр түвшинд гүйцэтгэж хамтын шийдвэр гаргаж ажиллахыг багийн бүх гишүүдэд үүрэг болгосугай.

3.Тус улсад хэрэгжиж буй донорын хууль, тушаал, журмыг хэрэгжүүлэн, багийн гишүүн бүрийн оролцоо, хамтын үйл ажиллагааг хангаж ажиллахыг Эмнэл зүй эрхэлсэн дэд захирал (Д.Сүнжидмаа)-д даалгасугай.

4.Тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж, ажиллахыг Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, чанар аюулгүй байдлын алба /Д.Зулаа/-д үүрэг болгосугай.

ЗАХИРАЛ



Д.ОЛОНБАЯР

3180710106